

“Шуудангийн илгээмж хүргэх хугацааг
тогтоох тухай”

Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6¹ дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Улс хоорондын болон дотоодын шуудангийн илгээмж хүргэх хугацааг дараах
байдлаар тогтоосугай. Үүнд:

1.1. Ердийн зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 2 хоног, аймаг, хотуудын
хооронд 5 хоног, бусад газар (улс хооронд)-т 12 хоногийн дотор;

1.2. Буухиа зэрэглэлийн илгээмжийг хүргэх хугацааг үйлчлэгч хоорондын
гэрээнд зааснаар тодорхойлох бөгөөд энэхүү тогтоолын 1.1 дэх хэсэгт заасан
хугацаанаас бага байхаар тогтоосугай.

2. Энэхүү тогтоолыг мөрдөж ажиллахыг холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд
үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга
/Г.Чинзориг/-д даалгасугай.

ДАРГА

ГИШҮҮД

¹Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх;

“Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох тухай”
ХХЗХ-ны тогтоолын төслийн танилцуулга

Шуудангийн тухай хуульд 2019 оны 05-р сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийн 9.1.6-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо нь шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр болсон.

Дэлхийн шуудан холбооны байгууллага болон бусад глобал сүлжээ (DHL, FedEx, UPS г.м)-ний шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох аргачлалд нийцүүлэн өөр өөр хөгжлийн түвшний үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд нийцэх боломжтой байх зарчимд үндэслэн мөн шуудангийн илгээмж хүргэх хугацааг мөрдүүлэх, хяналт тавих шалгуур үзүүлэлтийг тоон хэмжигдэхүүнээр илэрхийлэн үнэлэх аргачлалыг ХХЗХ-ны даргын 2019 оны А/295 тоот тушаалаар баталсан болно.

Дээрх аргачлалаар Шуудангийн тухай хуулийн 19.2 дахь заалтын дагуу шуудангийн илгээмжийг хүргэх хугацааг ердийн, буухиа гэсэн зэрэглэлээс хамааруулан дотоодын болон улс хоорондын гэсэн ангилалтайгаар тогтоосон.

Шуудангийн илгээмж хүргэх хугацааг шуудангийн илгээмжийг хэрэглэгчээс хүлээх авч, ялган боловсруулж, тээвэрлэн дамжуулж, хаягт эзэнд нь хүргэх хүртэл цаг, хоногоор илэрхийлнэ.

Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр батлагдаж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10-т “харилцаа холбоо” гэж цахилгаан холбоо, радио холбоо, өргөн нэвтрүүлэг, шуудангийн бүх төрлийг хэлнэ” гэж, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.13-д “дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх”, 9.15-д “улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр тус тус заасныг үндэслэн “Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах шаардлага үүссэн.

Дээрх хуулиудад нийцүүлэн “Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг ХХЗХ-ны 2023 оны 02-р сарын 28-ны өдрийн 23 тоот тогтоолоор шинэчлэн батлуулж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6194 дүгээрт бүртгүүлсэн бөгөөд цаашид дотоодын болон улс хоорондын шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох шаардлага үүсэж байна.

Иймд шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх чиг үүргийн хүрээнд шуудангийн илгээмж хүргэх хугацааг дараах байдлаар тогтоохоор тогтоолын төслийг боловсруулав.

1.Ердийн зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 2 хоног, аймаг, хотуудын хооронд 5 хоног, бусад газар (улс хооронд)-т 12 хоногийн дотор;

2.Буухиа зэрэглэлийн илгээмжийг хүргэх хугацааг үйлчлэгч хоорондын гэрээнд зааснаар тодорхойлох бөгөөд энэхүү тогтоолын 1.1 дэх хэсэгт заасан хугацаанаас бага байхаар тогтоолын төсөлд тусгасан.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО